



СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЕРӨӨ СУМЫН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2021 оны 04 сарын 15 өдөр

Дугаар А/70

Тавин

Газар эзэмшүүлэх тухай

Монгол улсын "Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль"-ийн 29 дүгээр зүйлийн 29.1.3-ын "г", Монгол улсын "Газрын тухай" хуулийн 21 дүгээр зүйлийн 21.4.3, 33 дугаар зүйлийн 33.1.1, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1 дэх зүйл, сумын иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2021 оны 01 дүгээр сарын 08-ны өдрийн 18 тоот тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Төр, төсвийн байгууллагын зайлшгүй хэрэгцээнд газар эзэмших хүсэлт гаргасан "Сэлэнгэ аймгийн Ерөө сумын соёлын төв" /РД:3744574, УБД:1370002040/-д Тавин багийн нутаг дэвсгэр Тавин 1-101 тоотод байрлах 4301003932 нэгж талбарын дугаар бүхий 2636 м² газрыг урлаг, соёлын байгууллагын зориулалтаар 60 жилийн хугацаатайгаар эзэмшүүлсүгэй.

2. Дээрхи газарт кадастрын зураглал хийж, нэгж талбарын хувийн хэрэг үүсгэн, гэрчилгээ олгож эрхийг нь баталгаажуулан, газар эзэмшигчийн улсын бүртгэлд бүртгэхийг Газрын даамал /З.Мөнхзаяа/-д даалгасугай.

3. Эзэмшилд олгогдсон газрын ашиглалт, хамгаалалтын байдалд хяналт тавьж ажиллахыг байгаль орчны хяналтын улсын байцаагч /Д.Алтантулга/-д хариуцуулсугай.

4. Газрын тухай хуулийн 58 дугаар зүйлд заасны дагуу газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгааг цаг тухайд нь хийлгэж байхыг, эзэмшил газрын 10-аас доошгүй хувийг ногоон байгууламжтай байлгахыг газар эзэмшигч /Сэлэнгэ аймгийн Ерөө сумын соёлын төв/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Б.СЭРГЭЛЭН